



**ОРХОН АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2026 оны 06 сарын 12 өдөр

Дугаар 4/53

Баян-Өндөр сум

「 Хяналт, шалгалт зохион байгуулах тухай 」

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Эрүүл мэндийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.1 дэх хэсэг, Монгол улсын Засгийн газрын 2026 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн “Эрүүл мэндийн салбарт авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай” 134 дүгээр тогтоол, Монгол улсын Ерөнхий сайдын 2026 оны 10 дугаар албан даалгавар, Улсын Онцгой комиссын даргын 2026 оны 03 дугаар тушаал, Эрүүл мэндийн сайдын 2026 оны 05 дугаар албан даалгаврыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Бүх шатны Эрүүл мэндийн байгууллагуудын гадна болон дотоод орчны аюулгүй байдлыг хангах, аюул ослоос урьдчилан сэргийлэх, эрсдэлийг арилгах үзлэг, хяналт шалгалт зохион байгуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүн, хуваарийг нэгдүгээр, үзлэг хяналт шалгалт зохион байгуулах нэгдсэн удирдамжийг хоёрдугаар, арга хэмжээний төлөвлөгөөг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Байгууллагын гадна болон дотоод орчны аюулгүй байдлыг хангах, аюул ослоос урьдчилан сэргийлэх, эрсдэлийг арилгах хариу арга хэмжээг шуурхай авч хэрэгжүүлэхийг Эрүүл мэндийн байгууллагуудын дарга, захирал нарт үүрэг болгосугай.

3. Үзлэг, хяналт шалгалтыг батлагдсан удирдамжийн дагуу зохион байгуулж, дүнг нэгтгэн Удирдлагын зөвлөлд танилцуулж, холбогдох тайлан мэдээг тогтоосон хугацаанд дээд шатны байгууллагад хүргүүлж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч Эмнэлгийн тусламжийн чанар эрсдэл, магадлан итгэмжлэл хариуцсан ахлах мэргэжилтэн (П.Хишгээ)-д даалгасугай.


4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Бодлого төлөвлөлт, хууль эрх зүй, тусгай зөвшөөрөл хариуцсан ахлах мэргэжилтэн (Б.Уртнасан)-д даалгасугай.

ДАРГА



Ц.МОНХЦЭЦЭГ

Эрүүл мэндийн газрын даргын
2026 оны 06 сарын 12 өдрийн
1/3 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт




ҮЗЛЭГ, ХЯНАЛТ ШАЛГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАХ АЖЛЫН ХЭСГИЙН
БҮРЭЛДЭХҮҮН, ХУВААРЬ

№	Бүрэлдэхүүн	Албан тушаал	Нэр	Хяналт хийх байгууллага	Чиг үүрэг
1	Ахлагч	ЭМГ-ын Эмнэлгийн тусламжийн чанар, эрсдэл, магадлан итгэмжлэл хариуцсан ахлах мэргэжилтэн	П.Хишгээ	БОЭТ Эрдэнэт клиник	Нэгдсэн үнэлгээ, зөвлөмж боловсруулах, үнэлгээ хийх
2	Нарийн бичиг	ЭМГ-ын Хяналт шинжилгээ үнэлгээ, дотоод аудит хариуцсан ахлах мэргэжилтэн	М.Бямбасүрэн	-	Нэгдсэн тайлан нэгтгэх, үнэлгээ хийх
3	Гишүүд	ЭМГ-ын Эмчилгээ чанар хяналтын улсын байцаагч	Д. Оюунтунгалаг	БОЭТ, Эрдэнэт сувилал	Үнэлгээ хийх, зөвлөмж өгөх
4		ЭМГ-ын Эрүүл ахуй, халдвар хамгааллын хяналтын улсын байцаагч	Б.Будсүрэн	БОЭТ Жаргалант сумын ЭМТ	Үнэлгээ хийх, зөвлөмж өгөх
5		ЭМГ-ын Эм, эмнэлгийн хэрэгслийн бодлогын хэрэгжилт, оношилгоо эмчилгээний технологи хариуцсан мэргэжилтэн	О.Анхбаяр	Нийцэл, Үйлсбадрах, Энхжихманди рваа	Үнэлгээ хийх, зөвлөмж өгөх
6		ЭМГ-ын Нийгмийн эрүүл мэндийн төв, бодлого төлөвлөлт хариуцсан ахлах мэргэжилтэн	Н.Мөнгөнцацралт	Баян-Өндөрмед нэгдсэн эмнэлэг, Хойд бүсийн Хавдрын оношилгоо эмчилгээний дэд төв, Эрхэст оргил	Үнэлгээ хийх, зөвлөмж өгөх
7		ЭМГ-ын Халдварт бус өвчний тандалт сэргийлэлт хариуцсан мэргэжилтэн	А.Хонгорзул	Ачит, Бадархундага Их тавт, Очир увидас, Шинэ эрин, Тайхар	Үнэлгээ хийх, зөвлөмж өгөх
8		ЭМГ-ын Гамшиг, НЭМ-ийн ноцтой байдлын	Б.Оюуномин	Хойд бүсийн Хавдрын	Үнэлгээ хийх, зөвлөмж

		үеийн тусламж үйлчилгээ, орчны асуудал хариуцсан мэргэжилтэн		оношилгоо эмчилгээний дэд төв, Оюу, Талын булаг	өгөх
9		ЭМГ-ын Уламжлалт анагаах ухаан, Сэргээн засах, хөгжлийн бэрхшээлтэй иргэний тусламж үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн	Т.Нарантуяа	Мөнхийн гэгээ, Учралтбаяр	Үнэлгээ хийх, зөвлөмж өгөх
10		ЭМГ-ын Сувилахуй, хөнгөвчлөх тусламж үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн	С.Энхзаяа	Мэндцэцэн, Анхны оч, Мөнхсүндэрл	Үнэлгээ хийх, зөвлөмж өгөх

Эрүүл мэндийн газрын даргын
2026 оны 06 сарын 12 өдрийн
1/55 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт



Үзлэг хяналт шалгалт зохион байгуулах нэгдсэн удирдамж

Нэг. Үндэслэл: Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар аюулгүй байдлыг сайжруулахад чиглэсэн хууль, журам стандартын хэрэгжилтийг хангах хүрээнд эрүүл мэндийн байгууллагуудын гадаад, дотоод орчны аюулгүй байдлыг хангах, эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар аюулгүй байдлыг сайжруулах, иргэн төвтэй тусламж үйлчилгээ үзүүлэх, ялангуяа хөгжлийн бэрхшээлтэй иргэд, ахмад настанд үзүүлэх тусламж үйлчилгээн дэх чирэгдлийг бууруулах, эрүүл мэндийн удирдах, гүйцэтгэх ажилтны сахилга хариуцлага, эмнэлгийн мэргэжилтний харилцаа хандлага ёс зүй, харилцаа хандлагыг сайжруулснаар үйлчлүүлэгчийн сэтгэл ханамж, эмнэлгийн тусламж үйлчилгээний хүртээмжийг дээшлүүлэх, аюулгүй ээлтэй орчинг эрүүл мэндийн байгууллага бүр бүрдүүлэх эрэлт хэрэгцээтэй байна.

Хоёр. Зорилго: Бүх шатны Эрүүл мэндийн байгууллагын гадна болон дотоод орчны аюулгүй байдлыг хангах, аюул ослоос урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулж, арилгах замаар үйлчлүүлэгчийн орчны аюулгүй байдлыг хангуулах, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар аюулгүй байдлыг сайжруулахад чиглэсэн хууль, журам стандартын хэрэгжилтийг хангахад оршино.

Гурав. Хугацаа: Үзлэг хяналт шалгалтыг 2026 оны 06 сарын 11-ны өдрөөс 2026 оны 06 дугаар сарын 16-ны өдрүүдэд зохион байгуулна.

Дөрөв. Хамрах хүрээ: БОЭТ, Хойд бүсийн хавдрын оношилгоо эмчилгээний дэд төв, “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын Эрдэнэт сувилал, Эрдэнэт клиник, сум, өрхийн эрүүл мэндийн төвүүд, хувийн хэвшлийн ортой клиникүүд

Тав. Үзлэг, хяналт шалгалтын чиглэл: Улсын онцгой комиссын 03 дугаар тушаал, ЭМС-ын 2026 оны 05 дугаар албан даалгавар, Унаж бэртэх эрсдлийг үнэлэх түүнээс урьдчилан сэргийлэх арга MNS6211:2019, Эрүүл мэндийн үйлчилгээнд тавих шаардлага MNS7014:2023 стандартын хэрэгжилтийг үнэлэх

1. Эмнэлгийн мэргэжилтний харилцаа хандлага, ёс зүй, дүрэм, журмын хэрэгжилтийг сайжруулах -3 шалгуур үзүүлэлт

2. Эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар аюулгүй байдлыг сайжруулах, иргэн төвтэй үйлчилгээ үзүүлэх чиглэлээр-5 шалгуур үзүүлэлт

3. Хөгжлийн бэрхшээлтэй иргэд, ахмад настанд үзүүлэх тусламжийг чирэгдэлгүй болгох чиглэлээр-2 шалгуур үзүүлэлт

4. Эмнэлгийн гадаад, дотоод орчин аюулгүй байдлыг хангах чиглэлээр 41 шалгуур үзүүлэлт

- Эрүүл мэндийн үйлчилгээнд тавих шаардлага MNS7014:2023 стандартын хэрэгжилт -1 шалгуур үзүүлэлт
- Байгууллагын гадна орчны аюулгүй байдал-12 шалгуур үзүүлэлт
- Барилга байгууламжийн аюулгүй байдал-6 шалгуур үзүүлэлт
- Дотоод орчинд тавигдах шаардлага-7 шалгуур үзүүлэлт
- Галын аюулгүй байдал-5 шалгуур үзүүлэлт
- Цахилгаан болон инженерийн аюулгүй байдал-5 шалгуур үзүүлэлт
- Хөдөлмөрийн аюулгүй байдал-5 шалгуур үзүүлэлт

Зургаа.Тайлагнах, үр дүнг тооцох

6.1. Үзлэг, хяналт шалгалтын дүн, зөвлөмжийг нэгтгэн 2026 оны 06 дугаар сарын 17-ны өдөр ЭМГ-ын Удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, ЭМБ-уудад хүргүүлнэ.

6.2. Хэрэгжилтийн тайланг 2026 оны 06 дугаар сарын 18-ны дотор ЭМЯ-нд хүргүүлнэ.

Долоо. Хүрэх үр дүн

1. Бүх шатны Эрүүл мэндийн байгууллагуудын гадаад, дотоод орчны аюулгүй байдал хангагдана.

2. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар аюулгүй байдлыг сайжруулахад чиглэсэн хууль, журам стандартын хэрэгжилт хангагдана.

3. Үйлчлүүлэгчийн сэтгэл ханамж, эмнэлгийн тусламж үйлчилгээний хүртээмж дээшилж, аюулгүй ээлтэй орчин бүрдэнэ.

Эрүүл мэндийн газрын даргын
2026 оны 06 сарын 12 өдрийн
А/33 дугаар тушаалын гуравдугаар хавсралт

9043446 2020030036

УЛСЫН ОНЦГОЙ КОМИССЫН ДАРГЫН 3 ДУГААР ТУШААЛААР БАТЛАГДСАН “ЭРҮҮЛ МЭНДИЙН
БАЙГУУЛЛАГЫН ОРЧНЫ АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ, АЮУЛ ОСЛООС СЭРГИЙЛЭХ ҮЗЛЭГ ЗОХИОН
БАЙГУУЛАХ БОЛОН “ЭМНЭЛГИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР ХҮРТЭЭМЖИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ,
АЖИЛТНУУДЫН САХИЛГА ХАРИУЦЛАГЫГ САЙЖРУУЛАХ ТУХАЙ “ЭМС-ЫН 05 ДУГААР АЛБАН ДААЛГАВРЫН
ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Хийх ажлууд	Хугацаа	Хариуцах эзэн	Хамтран ажиллах байгууллага
НЭГ.ЭМНЭЛГИЙН МЭРГЭЖИЛТНИЙ ХАРИЛЦАА ХАНДЛАГА, ЁС ЗҮЙ, ДҮРЭМ, ЖУРМЫН ХЭРЭГЖИЛТИЙГ САЙЖРУУЛАХ ЧИГЛЭЛЭЭР				
1.1.	Удирдлагын шийдвэр ил тод, ёс зүйн хэм хэмжээнд нийцсэн, үг үйлдлээр үлгэрлэсэн, шударга хариуцлагатай байх, Эрүүл мэндийн байгууллагуудын хэмжээнд ёс зүйн зөрчилд өртөх эрсдлийг үнэлэх	Хугацааны турш	ЭМБ-уудын дэргэдэх Ёс зүйн хэсгийн хороо, багууд	ЭМГ-ын дэргэдэх Эмнэлгийн мэргэжилтний Ёс зүйн салбар хороо
1.2.	"Эрүүл мэндийн ажилтны ёс зүйн дүрэм"-ийг үйл ажиллагаандаа чанд мөрдөж, үйлчлүүлэгчтэй зөв боловсон, хүндэтгэлтэй харилцах соёлыг эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийн дунд хэвшүүлэх сургалт зохион байгуулах	Хугацааны турш	ЭМБ-уудын дэргэдэх Ёс зүйн хэсгийн хороо	ЭМБ-уудын удирдлагууд
1.3	Эрүүл мэндийн байгууллагууд өргөдөл, гомдол, санал хүсэлтийг хүлээн авах утас, цахим хаягийг олон нийтэд ил тод байршуулан түгээх	Хугацааны турш	Бүх шатны ЭМБ-уудын удирдлагууд	ЭМГ
1.4	Эрүүл мэндийн байгууллагын үйл ажиллагаа, ажилтнуудын харилцаа, ёс зүйтэй холбоотой асуудлаар иргэд, байгууллагаас төрийн бүх шатны байгууллагад тавьсан өргөдөл,гомдол,санал хүсэлт, сошиал хуудсанд байршсан асуудлыг шуурхай шийдвэрлэж, үнэн зөв хариу мэдээлэл өгөх	Хугацааны турш	ЭМГ-ын УТХ, НЭМТ	ЭМБ-ууд
ХОЁР.ЭМНЭЛГИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР,АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ САЙЖРУУЛАХ,ИРГЭН ТӨВТЭЙ ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР				
2.1	Эрүүл мэндийн байгууллагуудын Эмчилгээ чанар аюулгүй байдлын алба, багуудын үйл ажиллагаанд мэргэжил арга зүйн	Хугацааны турш	ЭМГ-ын ЭТҮХ	ЭМБ-уудын ЭЧА, баг, Ёс зүйн

	дэмжлэг үзүүлэх, эрсдлийг эрт илрүүлэх, буруутгах бус суралцах, тасралтгүй сайжруулах соёлыг төлөвшүүлэх сургалт зохион байгуулах			хэсгийн хороо
2.2	Хүүхдийн болон бусад тасаг, нэгжүүдэд үзүүлж буй тусламж, үйлчилгээ нь хүүхдийн эрх, ашиг сонирхолд нийцсэн, ээлтэй орчинд явагдаж буй эсэхэд байнгын хяналт тавих, үйлчилгээ авахаар хандсан хүүхдийг буцаахгүй, шаардлагатай тусламж, үйлчилгээнд хамруулах	Хугацааны турш	БОЭТ	ЭМГ-ын ЭТҮХ, ХШХ
2.3	Яаралтай тусламжийг харьяалал харгалзахгүйгээр иргэдэд чирэгдэлгүйгээр үзүүлэх, урсгалд зохицуулалт хийх	Хугацааны турш	БОЭТ	ЭМГ-ын ЭТҮХ, ХШХ
2.4	Үйлчлүүлэгчийг эмнэлэгт хэвтэх болон гарах үед эрүүл мэнд, нийгэм-сэтгэл зүйн үйлчилгээ үзүүлэх, эмнэлгээс гарсны дараах тусламж, үйлчилгээний тасралтгүй байдлыг хангах "Үйлчлүүлэгчийг дэмжих алба"-ыг Сувилахуйн албаны дэргэд байгуулж, чиг үүргийг тодорхойлж, удирдлага арга зүйгээр хангасан эсэх	Хугацааны турш	БОЭТ	ЭМГ-ын ЭТҮХ, ХШХ
2.5	Эмнэлэг хооронд эмчлүүлэгчийг шилжүүлэх, мэдээлэл солилцох, хүлээлгэн өгөх үйл ажиллагааг журмын дагуу зохион байгуулах, эмнэлгийн тусламжийн тасралтгүй байдлыг хангахад чиглэсэн эмнэлэг доторх тасаг нэгжийн үйл ажиллагааны уялдааг хангах үйл ажиллагааг зохион байгуулах	Хугацааны турш	БОЭТ	ЭМГ-ын ЭТҮХ, ХШХ
ГУРАВ. ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭД БОЛОН АХМАД НАСТАНД ҮЗҮҮЛЭХ ТУСЛАМЖИЙГ ЧИРЭГДЭЛГҮЙ БОЛГОХ ЧИГЛЭЛЭЭР				
3.1	Хөгжлийн бэрхшээлтэй иргэд болон ахмад настнуудад эмнэлгийн тусламж, үйлчилгээг (бүртгэл, үзлэг, оношилгоо, эмчилгээний үйл ажиллагаанд) дараалал харгалзахгүй, түргэн шуурхай үзүүлэх орчин нөхцөл, зохион байгуулалтыг (цахим дугаар олголт, хөтөч ажиллуулах гэх мэт) бүрдүүлж ажиллах, дэмжлэгт хяналт хийж зөвлөмж өгөх	Хугацааны турш	БОЭТ	ЭМГ-ын ЭТҮХ, ХШХ
3.2	Эмнэлгийн ажилтан, албан хаагчдад хөгжлийн бэрхшээлтэй иргэдтэй харилцах мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх сургалт зохион байгуулах	Хугацааны турш	ЭМБ-ууд	ЭМГ-ын ЭТҮХ
ДӨРӨВ. Эрүүл мэндийн байгууллагын орчны аюулгүй байдлыг хангах, аюул ослоос сэргийлэх чиглэлээр :				
4.1	"Эрүүл мэндийн үйлчилгээнд тавих шаардлага" MNS7014:2023 стандартын хэрэгжилтэд үнэлгээ хийх	Хугацааны турш	ЭМБ-ууд	ЭМГ-ын ЭТҮХ, ХШХ, ХШҮМХ, УТХ, НЭМТ
4.2.	ЭМС-ын батласан Эрүүл мэндийн байгууллагын орчны аюулгүй байдлыг хангах, аюул ослоос сэргийлэх үзлэг зохион байгуулах төлөвлөгөөний дагуу бүх шатлалын ЭМБ-дад шалгуурын дагуу үнэлгээ хийх	Хугацааны турш	ЭМБ-ууд	ЭМГ-ын ЭТҮХ, ХШХ, ХШҮМХ, УТХ, НЭМТ

4.3	Улсын онцгой комиссын 03 дугаар тушаал, ЭМС-ын 2026 оны 05 дугаар албан даалгавар, Унаж бэртэх эрсдлийг үнэлэх түүнээс урьдчилан сэргийлэх арга MNS6211:2019, стандартын хэрэгжилтийг үнэлэх	Хугацааны турш	ЭМБ-ууд	ЭМГ-ын ЭТҮХ, ХШХ, ХШҮМХ, УТХ ,НЭМТ
4.4.	Үзлэг, хяналт шалгалтын дүн, зөвлөмжийг нэгтгэн 2026 оны 06 дугаар сарын 17-ны өдөр ЭМГ-ын Удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж,хэрэгжилтийн тайланг 2026 оны 06 дугаар сарын 18-ны дотор ЭМЯ-нд хүргүүлэх	Хугацааны турш	ЭМБ-ууд	ЭМГ-ын ЭТҮХ, ХШХ, ХШҮМХ, УТХ ,НЭМТ